

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖИНСТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

2026 оны 03 дугаар 26

Бодь

**Нэг.Байгууллагын түүхийн талаар**

**1.1.Байгууллагын байгуулагдсан шийдвэр, үүсэл:**

Монгол Улсын шинэ үндсэн хууль батлагдаж Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Засаг даргын Тамгын газрыг 1992 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Жинст сумын Засаг даргын Тамгын газар 12 орон тоотой анх байгуулагдаж, сумын Засаг дарга Л.Алтанхуяг,Засаг даргын Орлогч Ж.Вандандорж, Тамгын газрын дарга С.Тэгшбаяр, Санхүүгийн тасгийн дарга Ж.Төмөр, Нягтлан бодогч Ж.Цагаан, Нийгмийн даатгалын байцаагч Б.Мягмарсүрэн, Архив, бичиг хэргийн эрхлэгч Х.Буян, Нярав П.Мягмардаш, Жолооч Б.Лхасүрэн, нар томилогдон анхны Тамгын газар бүрджээ.

**1.2. Эрхэм зорилго**

Монгол улсын Засгийн газар болон аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сум орон нутгийн нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, төрийн нийгэм эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, хууль ёсыг чандлан сахиулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай хүргэхэд оршино.

Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогыг зүй зохистой тодорхойлон түүнийг хэрэгжүүлэхэд сумын иргэдийн бүтээлч, санаачилга, идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуулын үйл ажиллагааг дэмжин хамтран иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг ойртуулах, тэдний язгуур, эрх ашгийг дээдлэн төрийн захиргааны байгууллагыг чадварлаг, нээлттэй ил тод болгон төлөвшүүлж иргэн, нийгмийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлж ая тухтай ажиллаж амьдрах нөхцөл бүрдүүлэх нь Засаг даргын Тамгын газрын эрхэм зорилго юм.

**1.3. Үндсэн чиг үүрэг:**

Хууль тогтоомжийн эрх зүйн актын сургалт сурталчилгааг өргөжүүлж, ирэгдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, шударга, хүргэх, төсөв, санхүүгийн бие даасан байдлыг хангах, төсвийн сахилгыг бэхжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх.

**1.4. Алсын хараа**

Иргэний сонсож, тэдний оролцоог бүрэн хангасан, итгэл хүлээж чадахуйц иргэн төвтэй орон нутагт төрийн хууль тогтоомжийг эрх тэгш хүртээмжтэй үйлчилж “Иргэнээ дээдэлсэн”, “шилдэг” сум болгон хөгжүүлэх алсын хараатай ажиллаж байна.

### **1.5. Эрхэмлэх үндсэн зарчмууд “ИРГЭНЭЭ ДЭЭДЛЭХ- ИЛ ТОД- ХАРИУЦЛАГА”**

Төрийн захиргааны байгууллага болон түүний ажилтнууд энэхүү зарчмыг удирдлага болон үйл ажиллагаа нь иргэнээ дээдэлсэн, хуулийн хүрээнд ил ил тод шударга, хариуцлагатай, бүтээлчээр ажиллаж, ёс зүйн зөрчилгүй иргэдэд тэгш хүртээмжтэй төрийн үйлчилгээг хүргэнэ.

**Иргэнээ дээдэлсэн байх:** Хуулийг чандлах сахиж хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа мэргэжлийн өндөр ур чадвартай ажилтнуудын хүчээр хэрэгжүүлж, гүйцэтгэлийг удирдлага, үр дүнг хянаж, иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, иргэдийн эрх ашигт нийцүүлсэн шийдвэр гаргаж байхаар үйл ажиллагааны зохион байгуулалт дотоодын хяналтын тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлнэ.

**Ил тод байх:** Бодлого боловсруулах, шийдвэр гаргаж хэрэгжүүлэхэд иргэд, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлж, нээлттэй, ил тод, шударга, хурдтай байхын зэрэгцээ бодитой үнэн зөв мэдээ, мэдээллийг ашигладаг байх.

**Хариуцлагатай байх:** Улс, аймаг, нутгийн өөрөө удирдах байгууллагаас шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангах, биелэлтийг тооцож, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, өргөдөл, санал, гомдолыг шийдвэрлэх үндсэн үүргээ иргэдээрээ үнэлүүлэн хариуцлага хүлээх чадвартай.